

МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ

2015.01

Үзүүлэлтүүд:

ДНБ 7.8%	ГШХО өмнөх оноос 74.2% буурлаа.	Төсвийн тэнцэл (12.8) тэр бум төгрөг	Инфляци 9.8%	Чанаргүй зээл 31.7 тэрбум төгрөгөөр өслөө	Валютын нөөц 1649.9 сая ам.доллар
Өсөлтөнд ХАА салбар 14.4%, аж үйлдвэр, барилгын салбар 16.1%, үйлчилгээний салбар 4.8%-иар өсжээ.	ГШХО өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1556.3 сая ам доллар буюу 74.2 хувиар буурчээ.	Орлого 353.6 тэрбум төг, зарлага 366.4 тэрбум төг, тэнцэл 12.79 тэрбум төг алдагдалтай.	Өмнөх сараас 0.7% өссөн нь хүнсний бараа 0.9%, хувцас, бөс бараа, гутлын бүлэг 0.8%-иар өссөн байна.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 31.7 тэрбум төгрөг буюу 5.1%-иар өсөж 657.4 тэрбум төгрөгт хүрэв.	Өмнөх сараас 22 хувь буюу 298 сая ам.доллараар өсөж 1649.9 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш **1932.7 төгрөг**



Орон сууцны үнийн индекс **1.179**
Өмнөх сараас 0.9%-иар, жилээс 2.2%-иар буурлаа.



Монголбанкны бодлогын хүү **1%**-иар нэмэгдэж **13%**




Монгол Улсын гурван сая дахь иргэн 2015 оны нэгдүгээр сарын 24-нд мэндэлсэн. Гурван сая дахь иргэнийг 1000-ны нарийвчлалтайгаар, нэгдүгээр сарын нийт төрөлт, нас баралтыг нарийн тооцож Үндэсний статистикийн хорооноос тодруулжээ.

Эх сурвалж: ҮСХороо

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон сар бүрийн дундаж үнийг графикаар, оны эцсээр хүснэгтээр үзүүлээ.

Эх сурвалж: ҮСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд

(Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Хэлэлцээр
эхэллээ









2015 оны нэгдүгээр сарын 5-наас эхэлсэн “Таван толгой” төслийн II шатны хэлэлцээ амжилттай явж байгааг ажлын хэсгийнхэн онцолж буй. Тавантолгойн төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын сайд М.Энхсайхан ажиллаж байгаа бол дэд уулзалтуудыг хариуцсан ахлагчаар Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатарыг томилсон. УАБЗ-өөс Тавантолгойг саадгүй явуулах үүргийг Засгийн газарт өгсөн бөгөөд одоогийн байдлаар хэлэлцээ түр завсарлажээ

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

2015.01

<p>ДНБ</p>	<p>ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнэ (2014 оны урьдчилсан гүйцэтгэл) 15.4 их наяд төгрөг, өмнөх оныхоос 7.8 хувиар өслөө. Үүнд: ХАА-н салбар 14.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 16.1 хувь, үйлчилгээний салбар 4.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.</p>	 <table border="1"> <caption>ДНБ</caption> <thead> <tr> <th>Төрийн үйлчилгээний үйлдвэр</th> <th>Өсөлт (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>4У'13*</td> <td>11,6%</td> </tr> <tr> <td>1У'14*</td> <td>7,5%</td> </tr> <tr> <td>2У'14*</td> <td>5,3%</td> </tr> <tr> <td>3У'14*</td> <td>7,0%</td> </tr> <tr> <td>4У'14*</td> <td>7,8%</td> </tr> </tbody> </table>	Төрийн үйлчилгээний үйлдвэр	Өсөлт (%)	4У'13*	11,6%	1У'14*	7,5%	2У'14*	5,3%	3У'14*	7,0%	4У'14*	7,8%
Төрийн үйлчилгээний үйлдвэр	Өсөлт (%)													
4У'13*	11,6%													
1У'14*	7,5%													
2У'14*	5,3%													
3У'14*	7,0%													
4У'14*	7,8%													
<p>Төсөв</p>	<p>Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ нэгдүгээр сард 353.6 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 366.4 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 12.79 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 46.5 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 11.3 пунктээр илүү байгаа нь нөлөөллөө.</p>	 <table border="1"> <caption>Төсөв</caption> <thead> <tr> <th>Төрөл</th> <th>01'15</th> <th>01'14</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Орлого</td> <td>353,6</td> <td>353,8</td> </tr> <tr> <td>Зардал</td> <td>366,4</td> <td>413,1</td> </tr> <tr> <td>Тэнцэл</td> <td>(12,79)</td> <td>(59,3)</td> </tr> </tbody> </table>	Төрөл	01'15	01'14	Орлого	353,6	353,8	Зардал	366,4	413,1	Тэнцэл	(12,79)	(59,3)
Төрөл	01'15	01'14												
Орлого	353,6	353,8												
Зардал	366,4	413,1												
Тэнцэл	(12,79)	(59,3)												
<p>Валютын хани</p>	<p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцаа нэрлэсэн дундаж ханш 2015 оны 1 дүгээр сард 1932.7 төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 218.4 төгрөг буюу 12.7 хувь, өмнөх сар буюу 2014 оны 12 дугаар сараас 2.6 хувь буюу 49.7 төгрөгөөр сулраад байна.</p>													
<p>Инфляци</p>	<p>Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны нэгдүгээр сард өмнөх сарынхаас 0.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.8 хувиар өслөө. Ерөнхий индекс 2015 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 0.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.</p>	 <table border="1"> <caption>Инфляци</caption> <thead> <tr> <th>Хугацаа</th> <th>01'15</th> <th>01'14</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>сарын</td> <td>0,7</td> <td>1,7</td> </tr> <tr> <td>оны эхнээс</td> <td>0,7</td> <td>1,7</td> </tr> <tr> <td>жилийн</td> <td>9,8</td> <td>12,3</td> </tr> </tbody> </table>	Хугацаа	01'15	01'14	сарын	0,7	1,7	оны эхнээс	0,7	1,7	жилийн	9,8	12,3
Хугацаа	01'15	01'14												
сарын	0,7	1,7												
оны эхнээс	0,7	1,7												
жилийн	9,8	12,3												
<p>Гадаад валютын нөөц</p>	<p>Гадаад валютын улсын албан нөөц 2014 оны эцсийн байдлаар 1649.9 сая ам.долларт хүрч өмнөх сараас 22 хувь буюу 298 сая ам.доллараар өсөж, өнгөрсөн оны мөн үеэс 26.6 хувь буюу 598 сая ам.доллараар буурчээ. Ийнхүү Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 22 хувиар өсөхөд гадаадаас авсан хувийн хэвшлүүдийн валютын зээл нөлөөлжээ.</p>	 <table border="1"> <caption>Нийт албан нөөц</caption> <thead> <tr> <th>Сар</th> <th>Нөөц (сая ам.доллар)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>08'14</td> <td>1 361</td> </tr> <tr> <td>09'14</td> <td>1 543</td> </tr> <tr> <td>10'14</td> <td>1 398</td> </tr> <tr> <td>11'14</td> <td>1 352,1</td> </tr> <tr> <td>12'14</td> <td>1 649,9</td> </tr> </tbody> </table>	Сар	Нөөц (сая ам.доллар)	08'14	1 361	09'14	1 543	10'14	1 398	11'14	1 352,1	12'14	1 649,9
Сар	Нөөц (сая ам.доллар)													
08'14	1 361													
09'14	1 543													
10'14	1 398													
11'14	1 352,1													
12'14	1 649,9													
<p>MSE-20 индекс</p>	<p>Үнэт цаасны арилжаагаар 2015 оны 1 дүгээр сард 65.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 5.8 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 64.2 тэрбум төгрөг, арилжигдсан үнэт цаас 4.1 сая ширхэг буюу 3.5 дахин өссөн. ТОП-20 индекс 2015 оны 1 дүгээр сард 14517.2 болж, өмнөх сарынхаас 315.8 нэгжээр буурчээ. Энэ нь Монголын хөрөнгийн бирж дээрх сүүлийн хоёр жилийнхээс хамгийн өсөлттэй гарсан сар байлаа.</p>													

* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ





* Эх сурвалж Монгобанк

*Монголын хөрөнгийн бирж

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Санхүүгийн салбар

2015.01

<p>Мөнгө</p>	<p>Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны эхний сарын эцэст 10.3 их наяд төг болж, өмнөх сараас 311.3 тэрбум төг буюу 2.9%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 302.6 тэрбум төг буюу 3%-иар өсжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө сарын эцэст 732.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 77.3 тэрбум төг буюу 9.5%, өмнөх оны мөн үеэс 161.9 тэрбум төг буюу 18.1%-иар буурчээ.</p>	<p>Мөнгөний нийлүүлэлт</p> <p>(их наяд төгрөг, 1-р сарын байдлаар)</p>  <table border="1"> <thead> <tr> <th>Сар</th> <th>M2 (их наяд төгрөг)</th> <th>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний эзлэх хувь (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>10'14</td> <td>10.0</td> <td>8.1%</td> </tr> <tr> <td>11'14</td> <td>9.9</td> <td>7.7%</td> </tr> <tr> <td>12'14</td> <td>10.6</td> <td>7.6%</td> </tr> <tr> <td>01'15</td> <td>10.3</td> <td>7.1%</td> </tr> </tbody> </table>	Сар	M2 (их наяд төгрөг)	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний эзлэх хувь (%)	10'14	10.0	8.1%	11'14	9.9	7.7%	12'14	10.6	7.6%	01'15	10.3	7.1%																								
Сар	M2 (их наяд төгрөг)	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний эзлэх хувь (%)																																							
10'14	10.0	8.1%																																							
11'14	9.9	7.7%																																							
12'14	10.6	7.6%																																							
01'15	10.3	7.1%																																							
<p>Хадгаламж</p>	<p>Нийт хадгаламж 2015 оны нэгдүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 180.2 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 688.5 тэрбум төгрөг буюу 9.9 хувиар өсөж 7560.3 тэрбум төгрөг болсон. Валютын хадгаламж 11.5 хувиар өсөж 2195.5 тэрбум төгрөг, төгрөгийн хадгаламж 0.8 хувиар бууж 5364.5 тэрбум төгрөгт хүрэв.</p>	<p>Хадгаламж</p> <p>(их наяд төгрөг, 1-р сарын байдлаар)</p>  <table border="1"> <thead> <tr> <th>Сар</th> <th>Нийт хадгаламж (их наяд төгрөг)</th> <th>Төгрөгийн (зүүн)</th> <th>Валютын (зүүн)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>10'14</td> <td>6.8</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>11'14</td> <td>6.9</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>12'14</td> <td>7.4</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>1'15</td> <td>7.5603</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	Сар	Нийт хадгаламж (их наяд төгрөг)	Төгрөгийн (зүүн)	Валютын (зүүн)	10'14	6.8			11'14	6.9			12'14	7.4			1'15	7.5603																					
Сар	Нийт хадгаламж (их наяд төгрөг)	Төгрөгийн (зүүн)	Валютын (зүүн)																																						
10'14	6.8																																								
11'14	6.9																																								
12'14	7.4																																								
1'15	7.5603																																								
<p>Зээл</p>	<p>ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны эхний сарын эцэст 12.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 413.7 тэрбум төгрөг буюу 3.3%-иар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 их наяд төгрөг буюу 9.8% өслөө. Чанаргүй зээлийн хэмжээ 657.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 5.1% (31.7 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 13%-иар (75.6 тэрбум төгрөг) өссөн байна. Сүүлийн дөрвөн сарын хугацаанд нийт зээлийн хэмжээ дараалан буурч, чанаргүй зээлийн хэмжээ дөрвөн сар дараалан өсөөд байна.</p>	<p>Нийт зээлийн хэмжээ</p> <p>(тэрбум төгрөг, 1-р сарын байдлаар)</p>  <table border="1"> <thead> <tr> <th>Сар</th> <th>Нийт зээлийн хэмжээ (тэрбум төгрөг)</th> <th>Чанаргүй зээлийн эзлэх хувь (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>10'14</td> <td>12.1</td> <td>4.7%</td> </tr> <tr> <td>11'14</td> <td>12.1</td> <td>4.9%</td> </tr> <tr> <td>12'14</td> <td>12.1</td> <td>5.0%</td> </tr> <tr> <td>1'15</td> <td>12.1</td> <td>5.4%</td> </tr> </tbody> </table>	Сар	Нийт зээлийн хэмжээ (тэрбум төгрөг)	Чанаргүй зээлийн эзлэх хувь (%)	10'14	12.1	4.7%	11'14	12.1	4.9%	12'14	12.1	5.0%	1'15	12.1	5.4%																								
Сар	Нийт зээлийн хэмжээ (тэрбум төгрөг)	Чанаргүй зээлийн эзлэх хувь (%)																																							
10'14	12.1	4.7%																																							
11'14	12.1	4.9%																																							
12'14	12.1	5.0%																																							
1'15	12.1	5.4%																																							
<p>Ипотекийн зээл</p>	<p>2014 оны 11 дүгээр сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.1 хувийг Улаанбаатар хотод, 22.9 хувийг хөдөө орон нутагт олгосон байна. Хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.9 хувь буюу 100.7 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 15.2 хувь буюу 96.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 9 хувь буюу 57.1 тэрбум төгрөг Дорноговь аймагууд эзэлж байна.</p>	<p>Ипотекийн зээлийн хэмжээ</p> <p>(тэрбум төгрөг)</p>  <table border="1"> <thead> <tr> <th>Сар</th> <th>Ипотекийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)</th> <th>Нийт зээлдэгчдийн тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>01'14</td> <td>2.02</td> <td></td> </tr> <tr> <td>02'14</td> <td>2.12</td> <td></td> </tr> <tr> <td>03'14</td> <td>2.19</td> <td></td> </tr> <tr> <td>04'14</td> <td>2.28</td> <td></td> </tr> <tr> <td>05'14</td> <td>2.37</td> <td></td> </tr> <tr> <td>06'14</td> <td>2.44</td> <td></td> </tr> <tr> <td>07'14</td> <td>2.49</td> <td></td> </tr> <tr> <td>08'14</td> <td>2.55</td> <td></td> </tr> <tr> <td>09'14</td> <td>2.62</td> <td></td> </tr> <tr> <td>10'14</td> <td>2.70</td> <td></td> </tr> <tr> <td>11'14</td> <td>2.76</td> <td></td> </tr> <tr> <td>12'14</td> <td>2.84</td> <td></td> </tr> </tbody> </table>	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	Нийт зээлдэгчдийн тоо	01'14	2.02		02'14	2.12		03'14	2.19		04'14	2.28		05'14	2.37		06'14	2.44		07'14	2.49		08'14	2.55		09'14	2.62		10'14	2.70		11'14	2.76		12'14	2.84	
Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	Нийт зээлдэгчдийн тоо																																							
01'14	2.02																																								
02'14	2.12																																								
03'14	2.19																																								
04'14	2.28																																								
05'14	2.37																																								
06'14	2.44																																								
07'14	2.49																																								
08'14	2.55																																								
09'14	2.62																																								
10'14	2.70																																								
11'14	2.76																																								
12'14	2.84																																								

* Эх сурвалж Монголбанк


САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.01

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 61.9 сая ам.доллар буюу 9.4 хувь, үүний дотор экспортын хэмжээ 151.7 сая ам.доллар буюу 47.3 хувиар өсч, импортын хэмжээ 89.8 сая ам.доллар буюу 26.2 хувиар буурчээ. Гадаад худалдааны тэнцэл энэ сард 225.4 сая ам.долларын ашигтай гарч, экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 151.7 сая ам.доллар буюу 47.3 хувиар нэмэгджээ.



* Эх сурвалж ҮСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2014 оны арван хоёрдугаар сарын эцэст гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 541.8 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 26.1 сая ам.доллар буюу 4.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1556.3 сая ам доллар буюу 74.2 хувиар буурчээ.



* Эх сурвалж ҮСХ, МБ

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.01

Монгол Улсын гадаад өр, зээлжих зэрэглэл


Гадаад өр

Засгийн газрын нийт гадаад өр 3 596 сая ам.доллар байна.

2014 оны гуравдугаар улирлын байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 20.9 тэрбум доллар байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 14.6 хувь (2.8 тэрбум ам.доллар)-аар, өмнөх улирлаас 5.3 хувь (1 тэрбум ам.доллар)-аар өссөн байна.

Нийт өрийн 17 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төвбанкны өр, 7 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 17 хувийг бусад салбаруудыг өр, 52 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

Төвбанкны нийт өрийн 91 хувийг богино хугацаат, 9 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3 911,50	4 089,20	4 299,10	4 169,30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2 760,80	2 625,00	2 550,00	2 490,00
Засгийн газрын баталгаа	2 305,50	2 515,80	2 439,20	1 312,50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8 977,80	9 230,00	9 288,30	7 971,80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.01

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch	
	Монгол Улс	Тогтвортой	Сөрөг	Сөрөг
Огноо	2014.04.29		2013.12.13	

Standard & Poor's 4-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг урт хугацаанд “BB-” байсныг “B+” болгон бууруулж, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “B” болгон тогтоосон. Үүнээс өмнө манай улсын зээлжих зэрэглэл “BB+” гэсэн ангилалд багтаж байсан билээ. S&P : МУ-ын зээлжих зэрэглэлд 2014 оны дөрөвдүгээр сараас хойш өөрчлөлт гараагүй байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт 50 орчим хувиар буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо С ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг юм.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's өнгөрөгч оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B 2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

Уг шийдвэртэй холбоотойгоор тус агентлагийн зүгээс Монголын Засгийн газрын эзэмшлийн Хөгжлийн банкны зэрэглэлийн ирээдүйн төлвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан ба Хөгжлийн банкны хоёрдогч өглөгийг B1, хоёрдогч дунд хугацаат өрийн бичгийг B1 гэж үнэлсэн юм.

* Эх сурвалж <http://www.moodys.com/>
<http://www.standardandpoors.com/>
<http://www.fitchratings.com/>

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2015.01

Сарын онцлох үйл явдал

- 01.01-нд** Энэ оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Шилэн дансны тухай хуулийг төр засгийн байгууллагууд төдийгүй аж ахуйн тооцоот албан газрууд, нэгж байгууллагууд ч хэрэгжүүлж эхэлсэн. Шилэн дансны хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байгаа билээ.
- 01.05-нд** Таван толгойн нүүрсний ордод хөрөнгө оруулагчаар “Чайна Шэнхуа Энержи”, “Сумитомо” корпораци, “Энержи ресурс” ХХК-ийн хамтарсан түншлэл шалгарсан. Хөрөнгө оруулагчидтай хийх хэлэлцээр 2015 оны нэгдүгээр сарын 5-нд эхэлсэн.
- 01.12-нд** Ашигт малтмалын газар нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 216 тогтоол, Уул уурхайн сайдын тушаалыг тус тус үндэслэн 14 аймаг, сумдын нийт 104 405.5 га талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг дахин зарлаж, сонгон шалгаруулалтад оролцох саналыг 2015 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн өглөөний 09 цаг хүртэлх хугацаанд авсан байна
- 01.14-нд** Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн, 13.0 хувь болгох шийдвэр гаргалаа.
- 01.23-нд** Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас 2015 оны батлагдсан төсвийн орлогыг бодитойгоор дахин төлөвлөх, урсгал болон хөрөнгийн зардлыг орлоготойгоо уялдуулан дахин тооцох, Засгийн газрын бүтцэд гарсан өөрчлөлтийг төсөвт тусгах зорилгоор Засгийн газраас 2015 оны төсвийн тодотголыг УИХ-аар хэлэлцэж 1-р сарын 23-ны өдөр баталлаа.
- 01.24-нд** Монгол Улсын 3 сая дахь иргэн энэ 2015 оны 1 дүгээр сарын 24-нд мэндэлсэн байна. Гурван сая дахь иргэнийг 1000-ны нарийвчлалтайгаар, 1 дүгээр сарын нийт төрөлт, нас баралтыг нарийн тооцож тодруулжээ. Монгол Улсын 3 сая дахь иргэнээр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Нэгдсэн эмнэлэгт 1 дүгээр сарын 24-ний өглөө эцэг Энхтүвшингийн Хатанболд, эх Ганбатын Аззаяа нарын гэр бүлд мэндэлсэн охин тодорсон байна.
- 01.17-01.27** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Чех улсын Ерөнхийлөгч М.Земаны урилгаар тус улсад төрийн айлчлал хийж, үүний дараа Швейцарийн Холбооны улсын Давос хотноо болсон Дэлхийн эдийн засгийн 45 дахь удаагийн чуулга уулзалтад оролцоод нэг сарын 27-нд эх орондоо ирэв.
- 01.31-нд** Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын 2015-2016 оны хөгжлийн замаа хамтдаа сонгоё” санал асуулгыг үүрэн харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч компаниудын мессежээр дамжуулан авсан.

Тойм

2014 оны 11 дүгээр сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.1 хувийг Улаанбаатар хотод, 22.9 хувийг хөдөө орон нутагт олгосон байна. Хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.9 хувь буюу 100.7 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 15.2 хувь буюу 96.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 9 хувь буюу 57.1 тэрбум төгрөг Дорноговь аймагууд эзэлж байна. Ипотекийн зээлийн хувьд 2014 оны байдлаар зээлдэгчдийн тоо болон үнийн дүн тасралтгүй өссөн байна.

Таван толгойн нүүрсний ордод хөрөнгө оруулагчаар “Чайна Шэнхуа Энержи”, “Сумитомо” корпораци, “Энержи ресурс” ХХК-ийн хамтарсан түншлэл шалгарсан. Энэхүү Хөрөнгө оруулагчидтай хийх хэлэлцээр 2015 оны нэгдүгээр сарын 5-нд эхэлсэн. Хөрөнгө оруулагч Консерциум нь Таван толгойн нүүрсний ордод Төслийн санхүүжилт хэлбэрээр хөрөнгө оруулж, хөгжүүлэх юм. Төслийн санхүүжилт гэдэг нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудыг төсөлд татан оролцуулах хөрөнгө оруулалтын хэлбэр. Иймээс “Таван толгойн ордод хөрөнгө оруулж хөгжүүлэх”-тэй холбоотой бүхий л гэрээ, хэлэлцээр олон улсын стандарт, банкны шаардлага хангасан маргаангүй, ил тод байх шаардлагатай.

УИХ-ын чуулган 2015 оны нэгдүгээр сарын 23-нд төсвийн тодотголыг баталлаа. Төсвийн тодотголоор Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого талд авто бензин, дизелийн түлшний онцгой албан татварыг 228 тэрбум, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 60 тэрбум, өмч хувьчлалын орлогыг 17.9 тэрбум, хувь хүний орлогын албан татварын орлогыг 7.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Түүнчлэн улсын төсвийн урсгал зардалд “Алдарт эх”-ийн одонтой эхэд олгох тэтгэмжийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу бүх одонтой эхчүүдэд олгохоор тооцон 19.4 тэрбум төгрөг, Нийгмийн халамжийн сангаас олгох жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авдаг эсэхээс үл хамааран бүх эхчүүдэд олгохтой холбогдуулан орон нутгийн нийгмийн халамжийн сангийн зардалд 9.1 тэрбум, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор Нийгмийн даатгалын санд улсаас олгох татаасыг 13 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тооцжээ. Улсын төсвийн урсгал зардлыг улс төрийн албан тушаалтнуудын бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, ном хэвлэл, гадаад, дотоод албан томилолт, тойрогт ажиллах, зочин төлөөлөгч хүлээн авах, мэдээлэл сурталчилгааны болон мөрийн хөтөлбөрт туссан арга хэмжээний зардлыг 5 хувиар буюу 467.2 сая төгрөгөөр бууруулж тооцсон байна.

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын 2015-2016 оны хөгжлийн замаа хамтдаа сонгоё” санал асуулгыг үүрэн харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч компаниудын мессежээр дамжуулан авсан. 2015 оны нэгдүгээр сарын 31-ний 10.00 цагаас хоёрдугаар сарын 3-ны 22 цагийн хооронд иргэдээс мессежээр авсан санал асуулгад нийт 365 841 иргэн оролцжээ. Нийт саналын 63833 буюу 17,45 хувь нь хүчингүй болсон байна. Санал асуулгын дүнгээр хүчинтэй санал болох 302008 иргэний 169230 буюу 56,1 хувь нь “Оюутолгой болон бүтээн байгуулалтын том төслүүдийг шийдэх замаар ханшаа тогтоох” гэсэн нэгдэх хариултыг сонгож, 132778 иргэн буюу оролцогчдын 43,9 хувь нь “Зардал хэрэглээгээ бууруулж, эдийн засгаа сахилга батжуулах замаар ханшаа тогтоох” гэсэн хоёр дахь хариултыг сонгожээ.